|         |  |                |                |              |        |
|---------|--|----------------|----------------|--------------|--------|
| 2132    | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>                | 2,670,000.00   | 2,669,585.00   | 415.00       | 99.98  |
| 213209  | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал      | 2,670,000.00   | 2,669,585.00   | 415.00       | 99.98  |
|         | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>        | 411,368,300.00 | 409,010,668.24 | 2,357,631.76 | 99.43  |
| 1320    | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>        | 410,368,300.00 | 408,310,668.24 | 2,057,631.76 | 99.50  |
| 132001  | Орон нутгийн төсвөөс                         | 410,368,300.00 | 408,310,668.24 | 2,057,631.76 | 99.50  |
| 120004  | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b> | 1,000,000.00   | 700,000.00     | 300,000.00   | 70.00  |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих    | 1,000,000.00   | 700,000.00     | 300,000.00   | 70.00  |
| 61      | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>                      | 01.00          | 01.00          | 0.00         | 100.00 |
| 610001  | Төсвийн байгууллага                          | 01.00          | 01.00          | 0.00         | 100.00 |
| 62      | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>                      | 22.00          | 21.00          | 1.00         | 95.45  |
| 620001  | Удирдах ажилтан                              | 03.00          | 03.00          | 0.00         | 100.00 |
| 620002  | Гүйцэтгэх ажилтан                            | 19.00          | 18.00          | 1.00         | 94.74  |
| 65      | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>                   | 22.00          | 21.00          | 1.00         | 95.45  |
| 650001  | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)           | 09.00          | 08.00          | 1.00         | 88.89  |
| 650009  | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)   | 06.00          | 06.00          | 0.00         | 100.00 |
| 650011  | Улс төрийн албан хаагч (УТ)                  | 07.00          | 07.00          | 0.00         | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт   | Гүйцэтгэл            |
|------------|--|----------------------|
|            | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  |                      |
| I          | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>17,927,573.50</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>17,927,573.50</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 17,927,573.50        |
| 2108       | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | 17,927,573.50        |
| 210801     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 17,927,573.50        |
| II         | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | 17,927,573.50        |
| 1311       | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 17,927,573.50        |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 17,927,573.50        |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан зааврын дагуу анхан шатны баримтыг хөтлөх, төсөвт байгууллагад мөрдөгдөх мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөх, эд хөрөнгийн тооллогын баримт материалыг Төрийн аудитын байгууллагад бүрэн ирүүлэх зэрэг зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 190 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг ЗДТГ-ын дарга З.Цэрэндорж, 2 дугаар гарын үсгийг 2021.01.01-2021.02.09 хүртэлх хугацаанд М.Мөнхбат, 2021.02.10-2021.03.31 хүртэлх хугацаанд Г.Буянжаргал, 2021.04.01-2021.12.31 хүртэлх хугацаанд Б.Батбаяр нар зурж, нярваар 2021 оны 2021.01.01-2021.08.31 хүртэлх хугацаанд Г.Пүрэвсүрэн, 2021.10.01—2021.12.31 хүртэлх хугацаанд Л.Ганболд ажиллажээ.

### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Жинст сумын Засаг даргын Тамгын газар нь Засгийн газрын тогтоолоор захиргааны 5 багт хуваагдаж, улс төрийн албан тушаалтан 7, төрийн жинхэнэ албан хаагч 9, үйлчилгээний албан хаагч 6, нийт 22 орон тоо батлагдаж, жижиг дунд хариуцсан мэргэжилтэн 2021 оны 7 дугаар ажлаас чөлөөлөгдөж, 21 орон тоогоор ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх бодлогын баримт бичиггүй ба 2021 онд аймгийн хэмжээнд мөрдөгдөх 300.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 500,967.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,514.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,260.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 653,909.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 9,808.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,866.0 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,019,455.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 44,919.6 мянган төгрөгөөр буюу 4.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт                    | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт   |
|-----------------------------|----------------|-----------------|------------|
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН     | 71,812.0       | 17,504.5        | (54,307.4) |
| Авлага                      | 100.2          | 161.2           | 61.0       |
| Бараа материал              | 71,711.8       | 17,343.3        | (54,368.5) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 902,723.7      | 1,001,950.7     | 99,227.0   |
| Үндсэн хөрөнгө              | 1,323,715.0    | 1,489,084.2     | 165,369.2  |
| Хуримтлагдсан элэгдэл       | (420,991.3)    | (487,133.4)     | (66,142.1) |
| Нийт хөрөнгө                | 974,535.7      | 1,019,455.3     | 44,919.6   |

**Жинст сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

|  |           |             |          |
|--|-----------|-------------|----------|
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/        | 974,535.7 | 1,019,455.3 | 44,919.6 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 974,535.7 | 1,019,455.3 | 44,919.6 |

*Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан*

Тус байгууллагын төрийн сан банкны харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Тайлант хугацаанд 2 албан хаагчдаас 161.2 мянган төгрөгийн авлагатай гарсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

Оны эхэнд 71,711.8 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 68,515.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 94,508.6 мянган төгрөгийн бараа материал авч, 217,672.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, оны эцэст 17,063.3 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарчээ.

Оны эхэнд бүртгэлтэй 1,323,715.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж сумын ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан 32,800.0 мянган төгрөгийн хог тээврийн автомашин, Мал эмнэлгийн газраас үнэ төлбөргүй ирсэн зөөврийн компьютер, мини принтер, НҮБ-ийн санхүүжилтээр хийсэн худгийн сайжруулалтыг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор бүртгэжээ. Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.14-ний өдрийн 139 дүгээр тогтоолоор сумын ерөнхий боловсролын сургуулийн 75,416.3 мянган төгрөгийн био нойл, 60,306.4 мянган төгрөгийн үнэтэй дотуур байрыг ЗДТГ-т шилжүүлэх шийдвэр гарсны дагуу нийт 135,722.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг баланст шилжүүлэн бүртгэсэн байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.04.01-ний өдрийн 43-р тогтоолын 2 дугаар хавсралтаар 3,906.1 мянга, 2021.12.14-ний өдрийн 137-р тогтоолоор 11,026.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 2021 оны 95,103,117 дугаар тогтоолоор 13,693.7 мянган төгрөгийн орон сууц, 16,000.0 мянган төгрөгийн УАЗ-469 автомашиныг дуудлага худалдааг борлуулж, 2021.12.14-ний өдрийн 137-р тогтоолоор 1,317.0 мянган төгрөгийн хөгжмийг сумын ерөнхий боловсролын сургуульд шилжүүлэн, оны эцэст 1,489,364.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 44,919.6 мянган төгрөгөөр өсөж 1,019,455.3 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү акталсан үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний 23,064.4 мянган төгрөгөөр буурсан ба өмнөх оны үр дүн данс мөн дүнгээр өөрчлөлт орсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Жинст сумын Засаг даргын Тамгын газар 2021 оны төсвийн төлөвлөлтийг 404,050.0 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70106 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийг 2020.12.18-ний өдрийн сумын ИТХ-ын хуралдаанаар анх 383,689.6

| Анхны батлагдсан төсөв | 2021 оны 12 сард хийсэн тодотгосон төсөв |
|------------------------|--|
| 383,689.6              | 411,368.3                                |

мянган төгрөгөөр баталж, 2021 оны 7 дугаар сард 411,368.3 мянган төгрөг болж, анх батлагдсан төсвөөс 427,678.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Жинст сумын Засаг даргын Тамгын газар өөрийн орлогын төлөвлөгөөгөөр 1,000.0 мянган төгрөгийг оруулахаас гүйцэтгэлээр Хаан банкны түрээсийн орлогоор 700.0 мянган төгрөгийг оруулж, урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд батлагдсан 410,668.3 мянган төгрөгийг бүрэн авч 408,310.7 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 2,357.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 17,927.6 мянган төгрөгийн орлого орсныг зарцуулсан байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сумын Засаг даргын 2021.10.25-ний өдрийн а/126 дугаар захирамжаар сумын цагдаагийн албаны автомашины засварт 4,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

2021 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг албан хаагчдаас санал авч, цар тахлын үеийн нөхцөл байдалд нийцүүлэн, урт хугацааны төлөвлөгөөны заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 9 чиглэлээр, 46 ажил төлөвлөн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Жинст сумын Засаг дарга 92.3% гэж үнэлсэн байна.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн дүн нь аудитаар тооцсон материаллаг байдлаас хэтэрсэн, байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс хөрөнгийг бүрэн тоолоогүй, тооллогын дүнд үндэслэн нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй, байгууллагын 2020 оны санхүүгийн тайлангийн аудит, 2021 оны завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс зөрчил давтагдан гарсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг ....жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө заавал хийнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалт, санхүүгийн тайлангийн "Оршин байх", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Үнэлгээ" батламж мэдэгдлүүдийг хангахгүй тул "Хязгаарлалттай" дүгнэлтийг өгөв.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг шалгав.

Тус байгууллага нь 2021 онд нийт 461,138.1 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс 22,576.9 мянган төгрөгийн 9 мэдээллийг байгууллагын цахим хуудаст мэдээлээгүй байна.

### **3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Жинст сумын Засаг даргын 2021.12.15-ний өдрийн А/176 дугаар тушаалаар "Орон нутгийн мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангах, удирдах бүрэлдэхүүний албан хэрэгцээнд зориулсан хувцас хэрэгсэл худалдан авах"-д 3,000.0 мянган төгрөгийг зарцуулах шийдвэр гарч, ЗДТГ-ын 25 албан хаагчид нэг бүр нь 125,0 мянган төгрөгийн гадуур хувцас авч өгч "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.4 дэх "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх",
2. Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, бөхийн барилдаан зохион байгуулахад 12,320.0 мянган төгрөгийг зарцуулж, 1.6 дахь "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх",
3. Бичиг хэргийн зардалд батлагдсан батлагдсан 3,522.5 мянган төгрөгийг бүрэн зарцуулж дээрх тогтоолын 1.9 дэх "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах"
4. Тогтмол зардалд 17,148.1 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 17,060.4 мянган төгрөгийг зарцуулан тогтоолын 1.8 дахь "Байгууллагын цахилгаан, дулааны

эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, 2,085.3 мянган төгрөгийн зөрчилд тогтоосон 2 төлбөрийн акт, 52,683.6 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 2 албан шаардлагыг бүрэн биелүүлсэн байна.

Менежментийн захидлаар 20,368.1 мянган төгрөгийн зөрчилд акталж устгасан хөрөнгийг устгал хийсэн баримтыг үйлдээгүй, үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацааг буруу оруулснаас элэгдэл бодогдоогүй, нягтлан бодох бүртгэлд тавих хяналт сул, холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй зэрэг зөрчилд өмнөх аудитаар зөвлөмж өгсөн байхад зөрчил дахин давтагдан гарлаа.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 61,291.8 мянган төгрөгийн 14 алдаа зөрчил илэрснээс, санхүүгийн тайланд 980.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 3,308.5 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 24,306.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 32,696.4 мянган төгрөгийн 6 зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж хүргүүлэв.

### 4.1 Залруулсан алдаа

Жинст сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд дараах алдааг залруулав.

1. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 70.0 мянган төгрөгийн ДВД уншигч, 210.0 мянган төгрөгийн компьютерын хард авч үндсэн хөрөнгөд бүртгэсэн тул үндсэн хөрөнгөөс хасан бараа материалд бүртгэж,
2. Хаан банктай байгуулсан гэрээний дагуу халаалтын 7 сарын хугацаанд нийт 700.0 мянган төгрөг төлснийг өөрийн орлогоор бүртгэлгүй, урсгал үйл ажиллагааны санхүүжилтээр бүртгэсэн байсныг санхүүжилтээс хасан, өөрийн орлогоор залрууллаа.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн тайланд нийт 910,0 мянган ,төгрөгийн алдааг бараа материалын данс, өөрийн орлого дансанд залруулав.

### 4.2 Төлбөрийн акт

1. Сумын Засаг даргын 2021.12.15-ний өдрийн А/176 дугаар тушаалаар "Орон нутгийн мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангах, удирдах бүрэлдэхүүний албан хэрэгцээнд зориулсан хувцас хэрэгсэл худалдан авах"-д 3,000.0 мянган төгрөгийг зарцуулах шийдвэр гарсны дагуу 2021.12.17-ний өдөр иргэн М.Отгонжаргалаас нэг бүр нь 120.0 мянган төгрөгийн ажлын хувцсыг худалдан авч, албан хаагчдад олгосон байна.

Энэ нь "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.3 дахь "Энэ тогтоол

батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэснийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын албан хаагчдаар хувцасны 3,000.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох

2. Байгууллагын даргын тушаалаар ажилтан Б.Баяраад 2021 оны 3 дугаар сард 53.1 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно” гэснийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Ажилтан Б.Баяраагаар илүү олгосон цалингийн 53.1 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох

3. Аймгаас өвс тэжээл хүргүүлсний замын зардлыг жолооч О.Хүрэлтогоод олгохдоо хувь хүний орлогын албан татварт 3 дугаар сард 88.8 мянга, 4 дүгээр сард 66.6 мянган төгрөгийг суутгасан атлаа орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй, жолооч Б.Алтангэрэлд 1,000.0 мянган төгрөгийн тээврийн хөлснөөс 100.0 мянган төгрөгийн татварыг суутгаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 8 дугаар зүйлийн 8.1 дэх “Үйл ажиллагааны орлогод хуулийн этгээд байгуулахгүйгээр үйл ажиллагаа явуулж олсон дараах орлогыг хамруулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсөвт төвлөрүүлээгүй 255.4 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох

#### 4.3 Албан шаардлага

1. Жинст сумын Засаг даргын 2021.12.22-ний өдрийн а/182 дугаар захирамжаар “Хүүхдэдээ тайлагная, хүүхдээ сонсьё” ээлжит чуулганыг сумын ЕБС-тай хамтран зохион байгуулж, 2,600.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,300.0 мянган төгрөгөөр ухаалаг самбар авахаар баталж, 2021.12.23-ний өдөр “Некст электроникс” ХХК-д 1,300.0 мянган төгрөг шилжүүлсэн байхад хөрөнгийг орлогод аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** “Некст электроникс” ХХК-аас худалдан авсан 1,300.0 мянган төгрөгийн ухаалаг самбарыг орлогод авах албан шаардлага өгөх

2. Байгууллагын даргын хөрөнгө захиран зарцуулах тухай 12,863.1 мянган төгрөгийн 8 тушаал, 6,300.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй, орлогыг 3413.8 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 дахь "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны цахим хуудсанд 22,576.9 мянган төгрөгийн 9 мэдээллийг байршуулах албан шаардлага өгөх.

3. Завсрын аудитаар 2021 онд шинээр худалдан авсан болон өмнөх онд үлдэгдлээр байсан хөрөнгөөс түүврийн аргаар сонгож тулгахад 43 ширхэг 430.0 мянган төгрөгийн гэрэл цомгийг хүмүүст тараасан байхад зарлагадаагүй зөрчил илэрч, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэснийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөх

## 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Зардлын холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг зөрчин Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, бөхийн барилдаан зохион байгуулахад 12,320.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, Төрийн наадмаас бусад ойн арга хэмжээнд төсвөөс мөнгө зарцуулдаг явдлыг таслан зогсоох.

### 2. Зардлын холбоотой асуудал

2.1. **Илрүүлэлт:** Сумын Засаг даргын 2021.10.25-ний өдрийн а/126 дугаар захирамжаар сумын цагдаагийн албаны автомашины засварт 4,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.2. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

### 3. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

3.1. **Илрүүлэлт:** Тайлант онд болон өмнөх онд бэлтгэж, үндсэн хөрөнгөд бүртгэсэн 12520.8 мянган төгрөгийн 7 хөрөнгийн ашиглах жилийг 0-ээр, 2019 онд бүртгэсэн 3855.6 мянган төгрөгийн 3-р багийн контор гэсэн хөрөнгийн ашиглах жилийг -1-ээр оруулснаар тухайн хөрөнгөд элэгдэл бодоогүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг ашиглалтад оруулсан хугацаанаас нь тооцож, ашиглагдах жилийг санхүүгийн программд оруулж, хөрөнгийн элэгдлийг тайлант онд үнэн зөв илэрхийлэх.

#### 4. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Байгууллагын албан хаагчдын эзэмшиж байгаа эд хөрөнгийн картыг бүрэн хөтлөөгүй, албан хаагчдын гарын үсгээр албажуулаагүй, хөрөнгийн тооллогоор бараа материалыг тоолоогүй, тооллогоор тоолсон үндсэн хөрөнгийн дүн бүртгэлийн дүнгээс зөрүүтэй, нягтлан бодогч тооцоо бодсон акт үйлдээгүй, тайлант онд акталсан хөрөнгийг устгал хийсэн актыг үйлдээгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж: Албан хаагчдын ашиглаж байгаа эд хөрөнгийн картыг бүрэн хөтөлж, албажуулах, эд хөрөнгийн тооллогыг чанартай хийж, тооцоо бодсон актаар баталгаажуулж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

#### 5. Зардлын холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт: Цалингийн болон томилолтын урьдчилгааг өглөгөөр бүртгэсэн, санхүүгийн программд завсрын аудит хийснээс хойш орлогын дүнг засварласан, мөнгөн гүйлгээний журналд гүйлгээний утга, харилцагч байгууллагын нэрийг иргэдийн харилцах нэрээр оруулсан байна.

5.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын дагуу бүртгэлийг хөтөлж, санхүүгийн программд төлбөрийн хүсэлтийг үндэслэн гүйлгээний утга, харилцагч байгууллагын нэрийг бүрэн оруулж байх.

#### 6. Зардлын холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт: Нярвын дансаар бэлнээр олгосон 17,062.1 мянган төгрөгийн гүйлгээний кассын тайлан гаргаагүй байна.

6.2. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн |          | /мянган төгрөгөөр/ |        |               |        |                 |          |     |          |
|---|-------------------------------------|----------------------|----------|--------------------|--------|---------------|--------|-----------------|----------|-----|----------|
|   |                                     |                      |          | Үүнээс             |        |               |        | Зөвлөмж         |          |     |          |
|   |                                     | Тоо                  | Дүн      | Залруулга          |        | Төлбөрийн акт |        | Албан шаардлага |          | Тоо | Дүн      |
| 1 | Жинст сумын ЗДТГ                    | 14                   | 61,291.8 | 2                  | 980.00 | 3             | 3308.5 | 3               | 24,306.9 | 6   | 32,696.4 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---